



ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

**ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛ, ҮР ДҮНД
СУУРИЛСАН САНХҮҮЖИЛТИЙН
ТОГТОЛЦОО, ҮР НӨЛӨӨНД ХИЙСЭН
ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН
ХУРААНГУЙ ТАЙЛАН**

Эрүүл мэндийн даатгал, үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоо, үр нөлөөнд хийсэн гүйцэтгэлийн аудит

Аудитын зорилт: Эрүүл мэндийн даатгал, үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоо, үр нөлөөнд гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт гарган зөвлөмж боловсруулан дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулах

А. Эрүүл мэндийн даатгалын тогтолцоо, үйл ажиллагааны үр дүн, төрөөс баримтлах бодлогын баримт бичгийн хэрэгжилт хангагдсан эсэх

Б. Эрүүл мэндийн байгууллагаас даатгуулагчийн эрэлт, хэрэгцээ шаардлагад нийцсэн эрүүл мэндийн чанартай тусламж үйлчилгээ үзүүлж байгаа эсэх

Эрүүл мэндийн даатгал, үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоо, үр нөлөөнд хийсэн гүйцэтгэлийн аудит

Аудитад хамрагдсан байгууллагууд:



Аймгийн ЗДТГ,
Эрүүл мэндийн
газар



Эрүүл мэндийн
даатгалын хэлтэс,
Нийгмийн
даатгалын хэлтэс



Лавлагаа
шатлалын 2
эмнэлэг



Өрх, сумдын 3
эрүүл мэндийн
төв



Хөнгөлөлттэй
эмээр үйлчлүүлж
буй 8 эмийн сан



Эрүүл мэндийн даатгал, үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоо, үр нөлөөнд хийсэн гүйцэтгэлийн аудит

Гүйцэтгэлийн санхүүжилтэд шилжсэнээс үүссэн нөхцөл байдал

Давуу тал



Сул тал

- Эрүүл мэндийн байгууллагуудын санхүүжилт өмнөх оноос нэмэгдсэн
- Идэвхгүй санхүүжилтээс ухаалаг худалдан авалтын тогтолцоонд шилжсэн
- Лавлагаа шатлалын эмнэлгүүдийн төвлөрлийг сааруулсан
- Хүн амыг эрүүл мэндийн шалтгаанаар санхүүгийн хүндрэлд орохоос сэргийлж, сүүлийн үеийн дэвшилтэт технологийг нэвтрүүлэх нөөц бололцоог нэмэгдүүлсэн
- Орон нутгийн хүнд амд үзүүлэх тусламж үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлсэн, чанар хүртээмжийг сайжруулсан
- Албан хаагчдын нийгмийн баталгаа, цалин, урамшууллыг нэмэгдүүлж, хүний нөөцийн тогтвор суурьшилтай ажиллах боломжийг нэмэгдүүлсэн

- ЭМЯ, ЭМГ нь эрүүл мэндийн байгууллагуудыг бодлого чиглэлээр хангадаггүй
- Албан хаагчдад цалин урамшуулал олгох эрх зүйн орчин шинэчлэгдээгүй
- Хүн ам цөөн, сумдын эрүүл мэндийн төвүүдийн хувьд эрүүл мэндийн тусламж үйлчилгээ хангалтгүй, нэг иргэний санхүүжилт бага ноогддог учраас санхүүгийн хүндрэлд орсон
- Эрүүл мэндийн даатгалын системийн программ, хангамжийг цогцоор нь шийдээгүй, хөгжүүлэлт удаан, ажлын ачааллыг нэмэгдүүлсэн
- Орон нутгийн эрүүл мэндийн байгууллагуудад үзүүлэхээр гэрээнд заагдаагүй тусламж үйлчилгээг зайлигүй тохиолдолд үзүүлсэн үед санхүүжилтээ авч чаддаггүй
- Өртгийн жинг бодитой тооцоогүй, өртөг хуваах зарчим алдагдсан

Эрүүл мэндийн даатгал, үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоо, үр нөлөөнд хийсэн гүйцэтгэлийн аудит

Орон тооны хангалт 2021 онд 89.1%, 2022 онд 85.8%



хөдөө орон нутагт ирж
ажиллах сонирхол бага

орон сууц, түрээсийн
байр хомс

Улаанбаатар хотын
эмнэлгүүдтэй
харьцуулахад цалин хөлс
бага, нийгмийн баталгаа
муу

Эрүүл мэндийн даатгалын сангийн орлогын төлөвлөгөөний хэрэгжилт 52.7%

Огноо	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
2021 он	1,845.7	2,576.6	-730.9
2022 он	5,206.2	2,746.1	2,460.1
ДҮН	7,051.9	5,322.7	1,729.2



Шалтгаан:

ЭМДЕГ нь орлого, зарлагын тэнцлийг хангах зорилгоор аймгийн НДХ болон ЭМДХ-ээс санал авахгүйгээр орлогын төлөвлөгөөг шууд нэмэгдүүлсэн байна. Гүйцэтгэлийн санхүүжилтэд ишлэжсэнээс хойш зардлын төлөвлөгөөг бодитоор төлөвлөөгүй байна.

Эрүүл мэндийн даатгал, үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоо, үр нөлөөнд хийсэн гүйцэтгэлийн аудит



Гүйцэтгэлээр санхүүжилт авснаар лавлагаа шатлалын эмнэлгийн үйл ажиллагаанд үр нөлөө гарсан байна.

Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлж буй эрүүл мэндийн байгууллагууд нь өөр өөр программ хангамж ашигласан, программ хоорондын мэдээлэл солилцох байдал, уялдаа холбоо байхгүй байна.

Даатгуулагч:
"www.e-mongolia.mn"

Аймгийн Эрүүл мэндийн даатгалын хэлтэс:
www.health.gov.mn

Аймгийн Нэгдсэн эмнэлэг:
"e-health"

Өрхийн болон сумдын эрүүл мэндийн төвүүд "e-health" программыг ашиглаж байсан ба 2022 оны 09 дүгээр сараас эхлэн
"www.e-hospital.mn"

Энхбилэг хувийн эмнэлэг:
"Wings"

Эмийн сангууд:
"Orion pharm", "Odoo",
"Цэцэн"

Эрүүл мэндийн даатгал, үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоо, үр нөлөөнд хийсэн гүйцэтгэлийн аудит

2021, 2022 онд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний санхүүжилтэд хийгдсэн хяналтын үр дүнгийн хасагдал



Аудитаар нийт 183.6 сая төгрөгийн зөрчил илэрч, зөрчлийг арилгуулах 6 зөвлөмж өглөө.

Эрүүл мэндийн даатгал, үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоо, үр нөлөөнд хийсэн гүйцэтгэлийн аудит



Аймгийн дунд болон богино хугацааны баримт бичигт эрүүл мэндийн даатгалын чанар, хүртээмжтэй тогтолцоог хөгжүүлэх чиглэлээр дэвшүүлсэн арга хэмжээний үр дүнг тооцох хугацаа болоогүй байна.



Эрүүл мэндийн даатгалын үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоог үр дүнтэй явуулах хүний нөөц дутагдалтай, орон нутгийн эрүүл мэндийн байгууллагуудын хувьд ЭМДҮЗ-өөс баталсан шийдвэрийг хэрэгжүүлэхэд бодит нөхцөл байдалтай уялдахгүй хүндрэл бэрхшээл үүсэж байна.



Эрүүл мэндийн даатгалын сангийн орлогын төлөвлөгөөг 2022 онд 2.8 дахин нэмэгдүүлж төлөвлөсөн байна.



Эрүүл мэндийн даатгалын сангийн санхүүжилтийг зохих журмын дагуу хянаж, гүйцэтгэлийг бодитой тайлагнасан боловч эрүүл мэндийн байгууллагууд программын хөгжүүлэлтээс шалтгаалж гүйцэтгэлийн санхүүжилтийг дутуу авсан байна.



ЭМДЕГ нь 2022 оны өрх, сумдын эрүүл мэндийн төвүүдийн гэрээг дүгнэх талаар чиглэл өгөөгүй байна.



Гүйцэтгэлээр санхүүжилт авснаар лавлагаа шатлалын эмнэлгийн үйл ажиллагаанд үр нөлөө гарсан байна.



Эрүүл мэндийн байгууллагаас эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд хамрагдаж чадахгүй байгаа хүн амыг тодорхойлж, тусламж үйлчилгээнд хамруулах, хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр үр дүнтэй ажиллаагүй байна.



Хяналт шалгалт үр нөлөөгүй байна.



Өрх, сумдын ЭМТ-үүдийн хувьд цахим мэдээллийн системийг ашиглан иргэдийг шаардлагатай мэдээллээр хангах, чанартай тусламж, үйлчилгээг үзүүлэх нөхцөл бүрдээгүй байна.

ЗӨВЛӨМЖ

Аймгийн Нийгмийн бодлогын хэлтэст

- Эрүүл мэндийн даатгал, үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцооны чиглэлээр бодлогын түвшинд эрүүл мэндийн байгууллагуудад зөвлөгөө дэмжлэг үзүүлэх, аймгийн Эрүүл мэндийн газар, Эрүүл мэндийн даатгалын хэлтэстэй хамтран ажиллах

Аймгийн Эрүүл мэндийн газарт

- Эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагааг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, төрийн болон хувийн хэвшлийн ЭМБ-уудын хамтын ажиллагааг сайжруулах, эрүүл мэндийн байгууллагуудад хийгдсэн хяналт шинжилгээ үнэлгээний дагуу журамд заасан холбогдох арга хэмжээг авах, зөвлөмжийн хэрэгжилтийг тооцох, эргэх холбоотой ажиллах

Аймгийн Эрүүл мэндийн даатгалын хэлтэст

- Нэхэмжлэлийн хяналтаар илэрсэн алдаа, зөрчил, хасагдсан шалтгаан тайлбарыг гаргаж, дүн шинжилгээ хийж, тусламж үйлчилгээний чанарыг сайжруулахад чиглэсэн зөвлөмжийг ЭМБ-уудад өгөх, хамтарч ажиллах
- Эрүүл мэндийн даатгалын тухай хууль тогтоомж, эрүүл мэндийн даатгалын үйл ажиллагааг олон нийтэд сурталчлах, даатгуулагчийг шаардлагатай мэдээллээр хангах зэргээр хуулиар хүлээсэн үндсэн чиг үүргээ бүрэн хэрэгжүүлж ажиллах

Аймгийн Нэгдсэн эмнэлэгт

- Нэхэмжлэлийн хяналтаар илэрсэн алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх тал дээр анхаарч ажиллах, даатгал хариуцсан эмчийн хяналтыг сайжруулах, эмч нарыг программ ашиглалтын талаар тогтмол сургалтад хамруулах

Өрх, сумдын эрүүл мэндийн төвүүдэд

- Нэхэмжлэлийн хяналтаар илэрсэн алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх тал дээр анхаарч ажиллах, даатгал хариуцсан эмчийг давхар томилон ажиллуулах, эмч нарыг программ ашиглалтын талаар тогтмол сургалтад хамруулах



АНХААРАЛ ХАНДУУЛСАНД БАЯРЛАЛАА

Дэлгэрэнгүй дараах холбоосоор орж үзнэ үү.
www.audit.mn

2023 он